



ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ЗЭЭЛИЙН БАГЦ БОЛОН РЕПО
АРИЛЖААГААР АВСАН ЭХ ҮҮСВЭРЭЭР ШИНЭЭР
ЗЭЭЛ ОЛГОХ, ОЛГОСОН ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

| № | ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ | ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР | УУЛ УУРХАЙН БУС ЭКСПОРТЫН САЛБАР |
|---|--|--|---|
| 1 | Зээлийн ангилал | Зээлийн хугацаанд ангилал буураагүй төгрөгийн зээл байх (Хэвийн зээл) | Зээлийн хугацаанд ангилал буураагүй аж ахуйн нэгжийн төгрөгийн зээл байх (Хэвийн зээл) |
| 2 | Зээлийн үлдсэн хугацаа | 2 жилээс доошгүй байна | 2 жилээс доошгүй байна |
| 3 | Үнэт цаасжуулах зээлийн дээд хэмжээ | 500 сая төгрөг | 3 тэрбум төгрөг |
| 4 | Шинээр олгох зээл, дахин санхүүжүүлэх зээлийн харьцаа | 70 хувийг шинэ зээлд, 30 хувийг дахин санхүүжүүлэхэд ашиглана | 70 хувийг шинэ зээлд, 30 хувийг дахин санхүүжүүлэхэд ашиглана |
| 5 | Шинээр олгох, дахин санхүүжүүлэх зээлийн хүү | Репо арилжааны хүү +4 нэгж хувиас хэтрэхгүй байна | Репо арилжааны хүү +4 нэгж хувиас хэтрэхгүй байна |
| 6 | Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа | 6 сараас доошгүй байна | 6 сараас доошгүй байна |
| 7 | Зээлийг урьдчилан төлж болох эсэх | Болно | Болно |
| 8 | Зээлдэгчтэй холбоотой хуулийн хариуцлага хүлээсэн эсэх | Хүлээгээгүй | Хүлээгээгүй |
| 9 | ААН-ийн зээлийн тогтмол төлбөр төлөх боломж ¹ | Аж ахуйн нэгжийн хувьд: Сарын EBITDA (Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх орлого) нь зээлийн нэг удаагийн эргэн төлөлтөөс /сараар эргэн төлөлт хийгддэг бол/ багагүй байх Иргэдийн хувьд: Сарын ахиуц ашиг (Борлуулалтын орлогоос хувьсах зардлыг хассан дүн) нь зээлийн нэг удаагийн эргэн төлөлтөөс /сараар эргэн төлөлт хийгддэг бол/ багагүй байх | Сарын EBITDA (Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх орлого) нь зээлийн нэг удаагийн эргэн төлөлтөөс /сараар эргэн төлөлт хийгддэг бол/ багагүй байх |

| | | | |
|----|-----------------------------------|---|---|
| 10 | Үйл ажиллагааны тогтвортой байдал | Сүүлийн 6 сар тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн байх | Сүүлийн 6 сар тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн байх |
| 11 | Барьцаа хөрөнгийн төрөл | Үл хөдлөх ба хөдлөх хөрөнгө | Үл хөдлөх ба хөдлөх хөрөнгө |
| 12 | Барьцаа хөрөнгийн шалгуур | (i) Банкны шаардлагыг хангасан өөрийн өмчлөлийн эсвэл гуравдагч этгээдийн барьцааны зүйл байх; (ii) Барьцаа хөрөнгө нь шаардах эрхийн зөрчилгүй (ТЗК-руу шаардах эрх нь бүрэн шилжих боломжтой байх); (iii) Барьцаа хөрөнгө нь үнэт цаасны багцад багтаж байгаа хэвийн зээлээс өөр хэвийн зээлд давхар харьяалагдаж болно. Уг тохиолдолд зээл чанаргүй ангилагдсан тохиолдолд үнэт цаасанд харьяалагдах зээлийн төлбөрийг тухайн аж ахуйн нэгж тэргүүн ээлжид барагдуулахыг хүлээн зөвшөөрсөн байна; (v) Барьцаа хөрөнгийн үнэлгээг үнэт цаасжуулалт хийгдэхээс 6 сараас багагүй хугацааны өмнө хийсэн байх; (vi) Хөдлөх эд хөрөнгө барьцаалж буй тохиолдолд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан барьцаа хөрөнгө байна. | (i) Банкны шаардлагыг хангасан өөрийн өмчлөлийн эсвэл гуравдагч этгээдийн барьцааны зүйл байх; (ii) Барьцаа хөрөнгө нь шаардах эрхийн зөрчилгүй (ТЗК-руу шаардах эрх нь бүрэн шилжих боломжтой байх); (iii) Барьцаа хөрөнгө нь үнэт цаасны багцад багтаж байгаа хэвийн зээлээс өөр хэвийн зээлд давхар харьяалагдаж болно. Уг тохиолдолд зээл чанаргүй ангилагдсан тохиолдолд үнэт цаасанд харьяалагдах зээлийн төлбөрийг тухайн аж ахуйн нэгж тэргүүн ээлжид барагдуулахыг хүлээн зөвшөөрсөн байна; (v) Барьцаа хөрөнгийн үнэлгээг үнэт цаасжуулалт хийгдэхээс 6 сараас багагүй хугацааны өмнө хийсэн байх; (vi) Хөдлөх эд хөрөнгө барьцаалж буй тохиолдолд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан барьцаа хөрөнгө байна. |
| 13 | Зээл үнэлгээний харьцаа | Зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа нь 70 хувиас ихгүй байх | Зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа нь 70 хувиас ихгүй байх |
| 14 | Санхүүгийн гайлангийн шалгуур | Аж ахуйн нэгжийн хувьд: МУ-ын засгийн газрын 113-р тогтоолын 5.9.7-д ЖДҮ-ийн сүүлийн 2 жилийн баталгаажсан тайлан байх (Хэрэв 2 жилийн дотор байгуулагдсан бол байгуулагдсанаас хойших санхүүгийн баталгаажсан тайлан, шинээр үүсгэн байгуулагдсан бол эхлэлтийн баланс) | Сүүлийн 2 жилийн баталгаажсан гайлан байх (Хэрэв 2 жилийн дотор байгуулагдсан бол байгуулагдсанаас хойших санхүүгийн баталгаажсан тайлан, шинээр үүсгэн байгуулагдсан бол эхлэлтийн баланс) |

| | | | |
|----|-------|---|---|
| | | Иргэдийн хувьд: Банкны дотоод тайлан болон бусад баримт | |
| 15 | Бусад | (i) Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан, Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлдэг байх; (ii) Зээлдэгчтэй хамаарал бүхий этгээд нь чанаргүй зээлийн үлдэгдэлгүй байх (iii) Санхүүжилтийг зориулалтын бусаар ашигласан нь шалгалтаар тогтоогдсон тохиолдолд санхүүжилтийг эргүүлэх төлөх | (i) Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан, Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлдэг байх; (ii) Зээлдэгчтэй хамаарал бүхий этгээд нь чанаргүй зээлийн үлдэгдэлгүй байх (iii) Санхүүжилтийг зориулалтын бусаар ашигласан нь шалгалтаар тогтоогдсон тохиолдолд санхүүжилтийг эргүүлэх төлөх |

oOo